



ANNUAL REPORT

2025 оны үйл
ажиллагааны тайлан





Агуулга

1. ТУЗ-ийн даргын мэндчилгээ
2. Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
3. Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл
4. Компанийн онцлох үйл явдлууд
5. Дижитал шилжилт
6. Хүний нөөцийн бодлого, сургалт хөгжил, соёлын арга хэмжээ
7. Санхүүгийн гүйцэтгэл
8. Компанийн бүтэц, зохион байгуулалт
9. Дотоод хяналтын тогтолцоо
10. Эрсдэлийн удирдлага
11. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг
12. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд
13. ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тойм
14. Компанийн засаглал



Эрхэм хөрөнгө оруулагчид, харилцагчид, түншүүд ээ,

2025 он “Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК-ийн хувьд компанийн засаглал, хяналтын тогтолцоо, урт хугацааны хөгжлийн бодлогыг бэхжүүлсэн чухал жил байлаа. Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагааг хууль, зохицуулалтын шаардлага болон компанийн засаглалын зарчимд нийцүүлэн чиглүүлж, стратегийн зорилт, хяналт, бодлогын шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд төвлөрлөн ажиллав.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн стратегийн зорилтын хэрэгжилт, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, аудит, бүтэц зохион байгуулалт, бодлогын орчныг боловсронгуй болгох чиглэлд онцгой анхаарч ажилласан ба байгууллагын удирдлагын үр нөлөө, хяналтын тогтолцоо, стратегийн уялдааг бэхжүүлэхэд бодлогын түвшинд шаардлагатай дэмжлэг, чиглэлийг гаргалаа.

Мөн компанийн гүйцэтгэх удирдлагын баг тайлант жилийн зорилт, үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэхэд хариуцлагатай ажиллаж, байгууллагын өсөлт, хөгжлийн суурийг бэхжүүлэхэд зохих хувь нэмэр оруулсныг онцлон тэмдэглэж байна.

Цаашид бид компанийн урт хугацааны тогтвортой өсөлт, зөв засаглал, ил тод байдал, хариуцлагатай удирдлагын зарчмыг тууштай баримталж, хувьцаа эзэмшигчид болон нийт оролцогч талуудад үнэ цэн бүтээх бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болно.

Байгууллагын амжилт бүрийн ард зогсож буй ажилтнуудын тууштай хөдөлмөр, хөрөнгө оруулагчдын итгэл, харилцагч түншүүд, ТУЗ-ийн гишүүд та бүхэндээ амжилт хүсэж, талархал илэрхийлье.



Хүндэтгэсэн,

С. Жавзандулам

Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн дарга



Эрхэм хүндэт харилцагчид, түншүүд, хамт олон та бүхэндээ,

2025 он “Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК-ийн хувьд үйл ажиллагааны гүйцэтгэл, бизнесийн өсөлт, байгууллагын чадавхыг ахиулсан үр өгөөжтэй жил байлаа. Тайлант хугацаанд бид үндсэн үйл ажиллагааныхаа үр ашгийг сайжруулж, санхүүгийн үзүүлэлтүүдээ нэмэгдүүлэн, компанийн өдөр тутмын үйл ажиллагааны тогтвортой байдлыг ханган ажиллалаа.

2025 оны эцсийн байдлаар нийт хөрөнгө 332 тэрбум төгрөг, зээлийн багц 256 тэрбум төгрөг, эх үүсвэр 180 тэрбум төгрөг, цэвэр ашиг 22.8 тэрбум төгрөгт хүрсэн нь манай хамт олны хариуцлагатай ажил, үр ашигтай гүйцэтгэлийн бодит үр дүн юм. Мөн дижитал хөгжил, үйл ажиллагааны уялдаа, харилцагчид хүргэх үнэ цэнийг сайжруулах чиглэлээр тодорхой ахиц гаргасны дотор NetPay аппликейшний шинэчлэл онцлох байр суурь эзэллээ. Энэхүү шинэчлэл нь харилцагчийн хэрэглээний туршлагыг сайжруулах, үйлчилгээг илүү хүртээмжтэй, шуурхай хүргэх, компанийн дараагийн шатны дижитал хөгжлийн суурийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

Тайлант хугацаанд бид нийгмийн хариуцлагын хүрээнд боловсрол, эрүүл мэнд, урлаг, спортын салбарт чиглэсэн санаачилгуудыг дэмжин ажиллаж, байгууллагын нийгмийн үнэ цэн, эерэг нөлөөлөө нэмэгдүүллээ. Эрүүл мэндийн чиглэлд “Зүрх мартаггүй” төслийг дэмжин ажилласан бол боловсролын чиглэлд оюутан залуусын хөгжил, ур чадварыг дэмжих зорилгоор “NetFuture 50” тэтгэлэгт хөтөлбөрөө зарлалаа. Мөн урлаг, спортын салбарт авьяас чадвар, хичээл зүтгэлийг урамшуулсан томоохон төсөл, арга хэмжээг дэмжин оролцож, тухайлбал The Voice of Mongolia шоу төсөл, Монголын Үндэсний Волейболын Дээд Лигийн 2025–2026 оны улирал-ын хүрээнд ивээн тэтгэж, хамтран ажилласан нь байгууллагын хариуцлагатай, үнэ цэн бүтээгч байр суурийг улам бэхжүүлэв.

Энэхүү үр дүнд хүрэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан нийт хамтран зүтгэгчид, бидэнд итгэл хүлээлгэсэн харилцагчид, хамтран ажилласан түншүүд, хөрөнгө оруулагчиддаа чин сэтгэлийн талархал илэрхийлье. Цаашид бид санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг нэгтгэсэн, харилцагч төвтэй, хиймэл оюун ухаанд суурилсан экосистем бүтээх алсын хараандаа нийцүүлэн тогтвортой өсөлт, дижитал хөгжил, харилцагчдад хүргэх үнэ цэнийг тасралтгүй нэмэгдүүлэн ажиллах болно.

Хүндэтгэсэн,



Б.Хуншагай

Нэткапитал финанс корпораци
ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл



Нэткапитал эрхэм зорилго:

Дижитал шилжилтээр манлайлна




Нэткапитал алсын хараа:

Санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг нэгтгэсэн харилцагч төвтэй хиймэл оюун ухаанд суурилсан экосистем бүтээх



Үнэт зүйл:

Эрч хүчтэй байж бусдыг энергижүүл
Ил тод байж, итгэл даа
Гал эрмэлзэлтэй бай
Хурдтай гүйцэтгэ
Хөгжилтэй бай





Монгол Улсын ТОП 100 ААН-ийн нэгээр шалгарч, салбартаа тэргүүлээ

Харилцагчдынхаа итгэлийг хүлээсэн тэргүүлэгч банк бус санхүүгийн байгууллага болох Нэткапитал Финанс Корпораци нь 2008 онд үүсгэн байгуулагдсанаасаа хойш санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлаар салбартаа тэргүүлэгчийн байр сууриа бэхжүүлсээр ирсэн билээ. Энэхүү тууштай үйл ажиллагаа, менежментийн оновчтой бодлого, нийгмийн хариуцлагатай хандлагын үр дүнд тус Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарч, банк бус санхүүгийн салбартаа тэргүүлээ.





2025 оны онцлох ажлууд



Монгол телевиз - Ододтой бүжиглээ шоуны 2-р улирлын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав.

Англи улсын “BBC” телевизийн “Dancing with the Stars” (“Ододтой бүжиглээ”) шоу “Монгол ТВ” телевизээр албан ёсны эрхтэйгээр Монгол орон даяар хүргэхэд ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж, урлагаар дамжуулан эерэг нөлөөлөл бий болгох, авьяастнуудыг дэмжих нийгмийн ач холбогдол бүхий төсөлд бодит хувь нэмэр оруулав.



МУИС, ХААИС болон СЭЗИС-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.

Нэткапитал Санхүүгийн Групп Монгол улсын нэр хүндтэй боловсролын байгууллагууд болох Монгол Улсын Их Сургууль, Хөдөө Аж Ахуйн Их Сургууль болон Санхүү Эдийн Засгийн Их Сургууль-тай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж, оюутан залуусын хөгжил, судалгаа шинжилгээ, инновацыг дэмжих урт хугацааны түншлэлийг эхлүүлэв.



PMI Mongolia Chapter-с оюутан залуусын дунд зохион байгуулсан "Төслийн Удирдлагын Кейс" уралдааныг дэмжин ажиллалаа.

PMI Mongolia Chapter-ийн санаачилсан “Төслийн удирдлагын кейс” уралдаанд Нэткапитал Санхүүгийн Групп дэмжлэг үзүүлж, ирээдүйн төслийн менежерүүдийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд бодит хувь нэмэр орууллаа. Тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүнд Нэткапитал Санхүүгийн Группийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч С.Жавзандулам оролцож, ирээдүйн мэргэжилтнүүдийн ур чадварыг дэмжин шагналт байр эзэлсэн багуудад ажлын байрны урилга гардууллаа.



Анхны олон нийтэд нээлттэй 20% өгөөжтэй ХБҮЦ-г татан төвлөрүүлэв.

“Нэткапитал Эй Би Эс ТЗК” ХХК анхны олон нийтэд нээлттэй 20% өгөөжтэй Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас (ХБҮЦ)-ыг амжилттай арилжаалж, анхдагч зах зээлийн захиалга 100%-д хүргэн 30.0 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээ.



2025 оны онцлох ажлууд



Монголын Триатлоны Холбоотой хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.

Нэткапитал Санхүүгийн Групп нийгмийн хариуцлагын хүрээнд хурд, хүч, тэсвэр тэвчээрийг хамгийн өндөр түвшинд шаарддаг Триатлоны спортыг Монгол Улсад хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулахаар Монголын Триатлоны Холбоотой хамтран ажиллаж, ивээн тэтгэлээ.




NetPay апп шинэчлэгдэж хялбар шийдлийг дахин загварчлав.

2021 онд анх хэрэглээнд нэвтэрсэн NetPay аппликейшн дахин шинэчлэгдэж, хэрэглэгчдэдээ илүү ухаалаг, хялбар шийдлийг санал болгож байна. Шинэчлэлийн гол зорилго нь хэрэглэгчийн цаг хугацааг хэмнэж, хувийн санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй, ойлгомжтой, цөөн алхмаар шийдвэрлэхэд чиглэв.



Монгол телевиз - The Voice of Mongolia шоуны 4-р улирлын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав.

Шинэ шилдэг дуу хоолойг шалгаруулах "The Voice of Mongolia" шоу нэвтрүүлгийн 4-р улирлын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж үндэсний хэмжээнд олон мянган залуусын гал эрмэлзлийг бадрааж, уран бүтээлийн мөрөөдөлд нь шинэ эрч хүч өгч чадлаа.



IDCXS2022:02 стандартаа хамгаалан дахин баталгаажууллаа.

IDCXS 2022:02 стандартын баталгаажуулалтыг амжилттай дахин хамгаалж, байгууллагын хэрэглэгч төвтэй үйлчилгээний бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоо, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо олон улсын шаардлагад нийцэж буйг бататгасан бөгөөд харилцагчийн туршлагыг тасралтгүй сайжруулах стратегийн хэрэгжилтийн бодит илрэл юм.



2025 оны онцлох ажлууд



Монголын Үндэсний Волейболын дээд лигийн 2025-2026 улирлын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав.

Нэткапитал Санхүүгийн Групп нь Монголын Үндэсний Волейболын дээд лиг-ийн 2025–2026 оны улиралд ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж, волейболын спортыг хоёр дахь жилдээ тууштай дэмжин хөгжүүлэхэд хувь нэмэр оруулав.

Энэхүү хамтын ажиллагаа нь залуу тамирчдын хүсэл тэмүүлэл, ур чадварыг дэмжих, спортын соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн нийгмийн ач холбогдол бүхий санаачилга боллоо.



Нэткапитал Санхүүгийн Групп “NetFuture 50” оюутны тэтгэлэгт хөтөлбөрөө анх удаа хэрэгжүүллээ.

Сүндий сан-гийн санаачилгаар, Нэткапитал Санхүүгийн Групп-ийн ивээн тэтгэлгээр хэрэгжсэн “Net Future 50” хөтөлбөр нь залуу үеийн боловсрол, ур чадвар, хүсэл тэмүүллийг дэмжих өндөр ач холбогдол бүхий төсөл болж, шаардлага хангасан 300 гаруй оюутны материалыг хүлээн авснаас шилдэг 50 оюутныг шалгарууллаа.



“Бундан” ТББ-н Зүрх мартаггүй төсөлд хандив өгөв.

Нийгмийн сайн сайхны төлөө бодит үйл хэрэг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Нэткапитал санхүүгийн групп нь “Бундан” төрийн бус байгууллагын санаачлагаар хэрэгжиж буй “Зүрх мартаггүй” төсөлд дахин нэгдэж хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Нэткапитал санхүүгийн групп нь төрөлхийн зүрхний гажигтай 24 хүүхдийн зүрхний хагалгааны зардлыг дэмжиж, “Хайраар дүүрэн 24 зүрх” нэртэй нийгмийн хариуцлагын санаачилгыг хэрэгжүүлэхээр боллоо.



2025 оны онцлох ажлууд



3.0 сая ам.долларын санхүүжилт татав.

Олон улсын санхүүжилтийн эх үүсвэрийг тэлж, Enabling Capital нөлөөллийн сангаас 3.0 сая ам.долларын хөрөнгө татан төвлөрүүлэн хамтын ажиллагааг эхлүүлэв.



11.4 сая ам.долларын санхүүжилт татав.

Kilde Сингапурын хөрөнгө оруулалтын байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлж, 2.4 сая ам.долларын нэмэлт санхүүжилт татан төвлөрүүлэн дахин гэрээлэв. Ингэснээр нийт татан төвлөрүүлсэн санхүүжилтийн үлдэгдэл 11.4 сая ам.доллар болов.



Монголын Ресторан Зоогийн Газрын Холбоо-ны “MRA Awards 2025” ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав.

Нэткапитал Санхүүгийн Групп нь Монголын Ресторан Зоогийн Газрын Холбоо-ны “MRA Awards 2025” арга хэмжээний ерөнхий ивээн тэтгэгчээр оролцож, салбарын шилдгүүдийг тодруулах, үйлчилгээний салбарын хөгжлийг дэмжих ач холбогдол бүхий хамтын ажиллагааг хэрэгжүүлэв.



NetPay финтек апп ШИНЭЧЛЭГДЛЭЭ

NetPay апп шинэчлэгдэж super апп болох зорилгодоо нэг алхам ойртлоо.

Уламжлалт зээл шийдвэрлэх процессыг хялбарчлан, хэрэглээний болон бизнесийн зээлийг дижиталаар авах боломжийг хэрэглэгчдэдээ санал болгож байна.

NetPay аппын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор лоялти, хуримтлал болон хэрэгцээт үйлчилгээг шинээр нэвтрүүллээ.





Байгууллагын процессыг **Дижитал болголоо**

NETBASE ERP нь байгууллагын үйл ажиллагааг нэгтгэж, процессуудыг автоматжуулан, өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцоог бүрдүүлснээр дижитал шилжилтийг бодитоор хэрэгжүүлж байна.

Үр дүн:

Байгууллагын шийдвэр гаргах мэдээллийг нэг дор төвлөрүүлсэн.

Гар ажиллагаатай процессуудыг автомат болгож бүтээмжийг нэмэгдүүлсэн.

Байгууллагын засаглалын хувьд хяналт ба ил тод байдлыг нэмэгдүүлсэн.

Өдөр тутмын давтагддаг үйл ажиллагааг процесст оруулан зардлыг хэмнэсэн.



Шийдвэр гаргалт

Процессын автоматжуулалт

Хяналт бат ил тод байдал

Зардал хэмнэлт



Хүний нөөцийн бодлого

Бид алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, ёс зүйн дүрмийн хүрээнд хүний нөөцийн бодлого тодорхойлж компанийн хүн хүчний төлөвлөлт, хүний нөөц бүрдүүлэх, сонгон шалгаруулах, тогтоон барих, дасан зохицуулах, сургаж хөгжүүлэх, залгамж болон түлхүүр ажилтан бэлтгэх, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг тодорхойлон ажилладаг.

Бид ажилтныг бүрдүүлэх, сонгон шалгаруулах функц дээрээ хүний нөөцийн нээлттэй бодлого баримтлан ажиллаж байна. Компанийн зорилго ажилтан таны зорилготой нийцэж байхаар мэдлэг, ур чадвартай ажил горилогчийг “Зөв хүнийг, зөв албан тушаалд, зөв цагт” нь сонгон шалгаруулж авахыг зорин ажиллаж байна.

2024 оны эцсийн байдлаар Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК нь 595 идэвхтэй ажилтантай байсан бол 2025 оны 12 сарын 31-ний байдлаар 703 идэвхтэй ажилтантай болж, 108 ажлын байрыг шинээр бий болголоо.



703

Нийт идэвхтэй ажилтны тоо



177

Төв оффисын ажилтны тоо



526

Салбарын ажилтны тоо



13

Дээд шатны удирдлага



48

Нийт салбар



Тогтмол зохион байгуулагддаг идэвхжүүлэлтийн ажлууд

NetCup

1-р улирал

Нэгдсэн спортын арга хэмжээ



NetX

4-р улирал

Ажилтнуудын илтгэх ур чадварыг хөгжүүлэх
Ажил олгогчийн нэр хүнд, имиджийг таниулах



Шинэ ажилтны сургалт

Улирал бүр

Шинэ ажилтны дасан зохицуулах,
чиглүүлэх сургалт



NetVibe

Улирал бүр

Идэвхжүүлэлтийн арга хэмжээ



NetNaadam

3-р улирал

Баяр наадмын арга хэмжээ
Үндэсний хувцсаараа гоёх



NetSummer

3-р улирал

Нэгдсэн зуны зугаалгын арга хэмжээ






Санхүүгийн гүйцэтгэл


Нийт хөрөнгө: **+23%**

332 тэр.төг




Зээлийн багц: **+12%**

256 тэр.төг



Эх үүсвэр: **+15%**

180 тэр.төг






Санхүүгийн гүйцэтгэл

Цэвэр ашиг: **+62%**
22.8 тэр.төг

Ашигт ажиллагаа:
7.6% **24%**
⬆️ ROA ⬆️ ROE







Зохистой харьцааны тайлан

ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	12/31/2025	12/31/2024
НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	10%-аас доошгүй	40.0%	22.1%
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	20%-аас доошгүй	40.9%	22.1%
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	30%-аас доошгүй	47.5%	21.5%
ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	8%-аас дээш	15.4%	32.6%
ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	80%-аас хэтрэхгүй	65.6%	75.2%
ӨРИЙН БИЧГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	12.9%	41.6%



Компанийн бүтэц зохион байгуулалт





ТӨЛӨӨЛӨН УДИРДӨХ ЗӨВЛӨЛ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

		Хамгаалалтын 3 -р бүс	
Хамгаалалтын 1-р бүс		Хамгаалалтын 2-р бүс	
Салбар	<p>Суваг борлуулалтын удирдлагын газар Харилцагчийн амжилтын газар Брэнд, Маркетинг олон нийттэй харилцах газар Зээлийн газар Хөрөнгө оруулалтын борлуулалт, харилцагчийн удирдлагын газар Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, процесс хөгжүүлэлтийн газар Санхүү төлөвлөлт, нөөцийн удирдлага, шинжилгээний газар Санхүү бүртгэлийн газар Олон улсын санхүүжилт, эх үүсвэрийн газар Стратеги, гүйцэтгэлийн удирдлагын газар Зээлийн бүтээгдэхүүн процесс хөгжүүлэлтийн газар Хүний нөөц, соёлын газар Тусгай актив удирдлагын газар Дижитал бүтээгдэхүүний удирдлага, инновацын газар Хөрөнгийн зах зээлийн газар MT-н үйлчилгээ, аппЭнтерпрайз архитектур, технологи төлөвлөлтийн газарликэйшн ашиглалтын газар Бэкэнд инженерчлэлийн газар Фронтэнд инженерчлэлийн газар Дата аналитик, Бизнес Интеллекенсийн газар AI, машин сургалтын газар Дата инженерчлэлийн газар</p>	<p>Эрсдэлийн удирдлагын газар Хууль комплайнсын газар Зээлийн удирдлага (хяналт) Санхүү төлөвлөлт, нөөцийн удирдлага, шинжилгээний газар Санхүү бүртгэлийн газар Хүний нөөц, соёлын газар Мэдээлэл, кибер аюулгүй байдлын газар</p>	Дотоод аудитын газар
Журам дагаж мөрдөх, эрсдэлийг илрүүлэх, мэдээлэх, зайлсхийх, эрсдэлийг удирдах, дотоод хяналт хэрэгжүүлэх		<p>Эрсдэлийн хязгаар тогтоох хяналт хэрэгжүүлэх, заавар зөвлөмж аргачлалаар хангах, Эрсдэлийн удирдлагын газар тогтолцоог бүрдүүлэх</p>	Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хараат бусаар хяналт тавих, бусад аудит хийх



Эрсдэлийн удирдлага

Групп нь байгууллагын үнэ цэнийг хамгаалах, тогтвортой өсөлтийг хангах зорилгоор эрсдэлийн удирдлагын багийг байгуулан, үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй эрсдэлийн төрөл, шинж чанарыг тодорхойлж, үнэлэн, хянаж, удирдах тогтолцоог хэрэгжүүлж байна.

Эрсдэлийг үр дүнтэй удирдсанаар инновацыг дэмжих, байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах, бизнесийн тогтвортой байдлыг хангах боломжийг бүрдүүлж байна.

Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаа

Гүйцэтгэх захирлын эрх үүрэгт хамаарах эрсдэлийн удирдлагын хороо нь батлагдсан дүрэмд заасан бүрэлдэхүүн, давтамж, хэлэлцэх асуудлын дагуу 14 хоног тутам хуралдаж, эрсдэлийг хэлэлцэн, шийдвэрлэх арга хэмжээ авч ажилладаг.

2024 онд нийт 17 удаа хуралдсан бөгөөд үүсэж буй эрсдэлийг шийдвэрлэх, хяналтын тайланг хэлэлцэх, эрсдэлийн хязгаар лимитийн хэрэгжилтийг хянах, МУТСТ хууль, журам болон Зохицуулагч байгууллагын шалгуур, шаардлагыг хангуулах гэх мэт дүрэмд заасан хэлэлцэх шаардлагатай асуудлуудыг бүрэн хамруулж, шийдвэрийн хэрэгжилтийг Эрсдэлийн удирдлагын газраас хянаж байна.

Эрсдэлийн удирдах баримт бичгүүд

Группийн нийт эрсдэлийг дараах 8 ерөнхий төрөлд ангилж байна. Үүнд:

Стратегийн эрсдэл, Санхүүгийн эрсдэл, Зээлийн эрсдэл, Үйл ажиллагааны эрсдэл, Нийцлийн эрсдэл, Нэр хүндийн эрсдэл, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэл, Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлага
Дээрх эрсдэлийн төрөл тус бүрд нь эрсдэлийг удирдах журам болон арга аргачлалуудыг боловсруулан мөрдөж байна.

Эрсдэлийн удирдлагын засаглал, тогтолцоо

Групп нь эрсдэлийн удирдлагын засаглалаа 2023 онд Гүйцэтгэх захирлын эрх үүрэгт хамаарах хороодоор дамжуулан хэрэгжүүлсэн бол 2024 оноос ТУЗ-ийн дэргэд “Эрсдэлийн удирдлагын хороо”-г шинээр байгуулан ажиллаж байна.

Группийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын гурван бүсийн зарчим баримтлах ба эрсдэлийг хариуцах, хянах удирдах, засаглалыг бүрдүүлэх чиг үүргүүдийг хуваарилан ажилладаг.



Эрсдэлийн удирдлагын тогтолцоо



1. Стратегийн эрсдэлийн удирдлага

Группийн стратегийн төлөвлөгөөнд нөлөөлөх гадаад болон дотоод орчны эрсдэл, боломжуудыг Гүйцэтгэх удирдлагын баг жил бүр үнэлэн шинэчилж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг. Эдгээр арга хэмжээний хэрэгжилт болон үр нөлөөг OKR аргачлалд үндэслэн тогтмол хянаж, стратегийн зорилтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Групп нь санхүүгийн эрсдэлийг хяналттай удирдах зорилгоор Зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, активын төвлөрөл, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ болон үндсэн хөрөнгийн харьцааг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байлгаж, тогтвортой байдлаа хадгалан ажиллаж байна.

3. Зээлийн эрсдэлийн удирдлага

Групп нь “Зээлийн эрсдэлийг удирдах журам”-ын хүрээнд зээлдэгч, зээлийн бүтээгдэхүүн, барьцаа хөрөнгийн эрсдэлийн хязгааруудыг тодорхойлон, зээлийн багцыг оновчтой бүрдүүлэх зарчимд тулгуурлан ажиллаж байна.

Мөн зээлийн эрсдэлийн дохиог эрт илрүүлэх системийг хэрэгжүүлж, зээлдэгчийг таних скорингийн загварт тасралтгүй сайжруулалт хийж, барьцаа хөрөнгийн үнэлгээний процессыг автоматжуулах замаар хүнээс хамаарах эрсдэлийг бууруулах бодлого баримталж байна.

4. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Групп нь үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор ISO 9001:2015 стандартад нийцүүлэн SIPOC зураглалын аргачлалаар байгууллагын нийт процессын хүрээнд эрсдэлийг тодорхойлж, үнэлгээ хийдэг. Үүний үндсэн дээр боловсруулах хариу арга хэмжээг төлөвлөж, түүний хэрэгжилтийг улирал бүр хянан, тасралтгүй сайжруулалт хийж байна.

5. Нийцлийн эрсдэлийн удирдлага

Групп нь Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай (МУТСТ) хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмуудын дагуу нийцлийн эрсдэлийг удирдах журмыг боловсруулан баталж, тогтолцоог бүрдүүлэн хэрэгжүүлж байна. Энэхүү тогтолцооны хүрээнд эцсийн өмчлөгчийг тодорхойлох, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хориг жагсаалтад багтсан этгээдийг илрүүлэх зэрэг өндөр эрсдэл бүхий харилцагчийг тодорхойлох автоматжуулсан системийг нэвтрүүлж, хууль, зохицуулалтад нийцээгүй харилцаа, гүйлгээ үүсэхээс сэргийлж байна.



6. Нэр хүндийн эрсдэлийн удирдлага

Групп нь нэр хүндийн эрсдэлийг “эрсдэлийн аппетит”-даа тусган, цахим орчны сөрөг мэдээллийн тоо, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ (CSAT), санал болгох индекс (NPS), хэрэглэгчийн хүчин чармайлтын индекс (CES), асуудал шийдвэрлэсэн түвшин (CCR), анхны холбоогоор шийдвэрлэсэн хувь (FCR) зэрэг голлох үзүүлэлтүүдээр сар бүр хэмжилт хийж, дүн шинжилгээг Эрсдэлийн хороонд тогтмол тайлагнаж байна.

7. Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

Салбарын өрсөлдөөн технологийн хурд, мэдээлэл боловсруулах болон солилцох чадвараар тодорхойлогдож буй өнөөгийн нөхцөлд мэдээллийн технологи болон аюулгүй байдлын эрсдэл шууд хамааралтайгаар өсөн нэмэгдэж байна. Иймд байгууллагын үнэ цэнтэй мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах зорилгоор Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог (МАБМТ) дараах хяналтын арга хэмжээг ашиглан хэрэгжүүлж байна:

Хортой кодын эсрэг хамгаалалт, Физик нэвтрэлтийн хяналт, Системийн эмзэг байдлын хяналт, Эрхийн зохицуулалт Логийн удирдлага, Дижитал шинжилгээ (digital forensics).

Групп нь ISO/IEC 27001:2013 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд хоёр дахь жилдээ амжилттай магадлан аудит хийлгээд байна.

8. Байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

1. Групп нь байгаль орчин болон олон нийтэд сөрөг нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд хориглох чиг үүрэг бүхий салбар, үйл ажиллагааг “Эрсдэлийн удирдлагын бодлого”-д тодорхойлон тусгасан байдаг.
2. Нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтэд чиглэсэн төсөл, арга хэмжээнд зориулсан тусгай санхүүжилт батлан, хэрэгжүүлдэг.
3. Хөдөлмөр, эрүүл мэнд, аюулгүй байдлын чиглэлээр нийт ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрны аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлийг урьдчилан сэргийлэх арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж байна.



Дотоод аудитын зорилго

Дотоод аудитын газар нь “Нэткапитал Финанс корпораци ББСБ” ХХК-ийн компанийн засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны үр нөлөө, үр ашигт байдалд хараат бус, бодитой, эрсдэлд суурилсан үнэлгээ хийж, тэдгээрийг тасралтгүй сайжруулахад чиглэсэн баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг үзүүлэн ажилладаг. Энэхүү үйл ажиллагаагаар дамжуулан байгууллагын үнэ цэнийг бий болгох, хамгаалах, тогтвортой хадгалах чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Дотоод аудитын тогтолцоо

1. Дотоод аудитын газар нь хараат бус байх бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд үйл ажиллагааны хувьд харьяалагдаж, тайлагнана. Аудитын хороо нь дотоод аудитын дүрэм, эрсдэлд суурилсан жилийн аудитын төлөвлөгөө, төсөв болон нөөцийн төлөвлөгөө, дотоод аудитын газрын захирлын томилгоо ба чөлөөлөлт, гүйцэтгэлийн үнэлгээ, гадаад чанарын үнэлгээ, сайжруулалтын төлөвлөгөө, мөн хараат бус байдал болон байгууллагын эрсдэлийн хүлцэх түвшнээс давсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
2. ДАГ нь нэгж аудитыг сонгох, аудитын хамрах хүрээ, зорилго, шалгуур үзүүлэлт, аудитын давтамж, тайлангийн агуулгыг тодорхойлохдоо компанийн бусад газар, нэгжийн нөлөөллөөс ангид байна. Ингэснээр хараат бус, бодитой хандлагыг бий болгоно. Хараат бус, бодитой хандлага алдагдсан эсвэл алдагдах нөхцөл үүссэн тохиолдолд Аудитын хороонд мэдэгдэнэ.

Дотоод аудитын бүтэц ба зохион байгуулалт

1. ДАГ нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд шууд харьяалагдаж тайлагнана.
2. ДАГ нь газрын захирал, ахлах аудитор, мэдээллийн технологийн аудитор, аудитор гэсэн бүтэцтэй байна.
3. ДАГ нь Олон улсын дотоод аудитын стандарт ба ёс зүйн дүрэм, Дотоод аудитын газрын бодлого, дүрэм, журамд нийцэж ажиллана.





ТУЗ-ийн хараат бус гишүүд-2025



Б.МӨНХЖАВХАА
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оны 12 сараас компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

2021-2022: Захирал, "Growth source" ХХК

2007-2020: Хүний нөөцийн газрын захирал, Худалдаа Хөгжлийн банк



Ш.ЧУДАНЖИЙ
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2020 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

2017- Одоо: Захирал, СПЕК ХХК

1999-2009: CEO, Зоос банк

1993-1999: Эдийн засагч, МХАА-н банк



С.ОРГОДОЛ
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2024 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

2020-2024 Эрсдэл хариуцсан захирал, Богд банк

2009-2020: Гүйцэтгэх захирлын орлогч, Худалдаа Хөгжлийн Банк

2008-2009: ТУЗ-ийн дарга, Монгол Шуудан Банк



Л.ОРГИЛ
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

2020 - одоо: Гүйцэтгэх захирал, Хаан даатгал ХХК

2019 - 2020: Санхүү эрхэлсэн захирал, Хаан даатгал ХХК

2014 - 2019: Борлуулалт, сувгийн удирдлагын хэлтэс, Иргэдийн даатгалын хэлтэс захирал, Хаан Даатгал ХХК

2011-2014: Эдийн засагч, Эрэл ХХК



Б.БОЛОРЧИМЭГ
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2021 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

2019-одоо: Гүйцэтгэх захирал, Үүсгэн байгуулагч, Ворд медиа ХХК, Өрөг.мн

2012-2019: Сэтгүүлч, Шинэ дэлхий, MNC, NT телевиз



А.УРАНГОО
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн


Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2020 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ажлын туршлага:

2013-Одоо: CEO, Үүсгэн байгуулагч, UA Consulting, Properties, Investment



ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тойм



ТУЗ-ийн хурал

Хурлын тоо **19**

Шийдвэрийн тоо **35**

Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны Засаглалын кодекст нийцүүлж, дараах шийдвэрүүдийг гарган ажиллав.

1. Компанийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, Компанийн 2024 оны төсөв батлах тухай
2. Дотоод аудитын 2024 оны тайлан, 2025 оны төлөвлөгөөг батлах тухай
3. Засаглалын кодексын тайлан, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг үйл ажиллагааны журам шинэчлэн батлах тухай, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг гишүүд шинэчлэн батлах тухай
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан дуудуулах тухай
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд шинээр хороо байгуулах тухай
7. Компанийн бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлах тухай



ТУЗ-ийн дэргэдэх **хороо**



Эрсдэлийн удирдлагын хороо

Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг хэлэлцэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний шийдвэр гаргах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангах

Дарга: **С. Оргодол**

Гишүүн: **А. Урангоо**

Гишүүн: **С. Жавзандулам**

Нэр дэвшүүлэх, Цалин урамшуулал, засаглалын хороо

Компанийн ТУЗ-ийн гишүүд, компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллыг талаар баримтлах бодлогыг баталж, хянана.

ТУЗ-ийн гишүүн болон компанийн эрх бүхий албан тушаалтанд тавигдах шаардлага, гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, ТУЗ-ийн гишүүн, түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигчид нь тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэн шалгаж, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах болон томилогдон ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүд нь шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллахад анхаарах.

Жил бүр стратеги болон бизнес төлөвлөгөөний түлхүүр үзүүлэлтээс хамаарч гүйцэтгэх удирдлагын багийн цалин урамшууллыг тухайн жилийн 1-р улиралд багтаан ТУЗ-аар батлуулдаг.

Дарга: **Б. Мөнхжавхаа**

Гишүүн: **Б. Болорчимэг**

Гишүүн: **С. Жавзандулам**

Аудитын хороо

Хараат бус ба бодитой байдлыг хангах, аудитын нөөц, аудитын хамрах хүрээний хязгаарлалт, аудитын жилийн төлөвлөгөөг батлах, аудитын тайлагналын процесс, ерөнхий аудиторыг томилох, чөлөөлөх, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Дарга: **Л. Оргил**

Гишүүн: **Ш. Чуданжий**

Гишүүн: **С. Жавзандулам**

Тогвортой хөгжил нийгэм, засаглалын хороо

Тогтвортой хөгжил, нийгэм, засаглалын хорооКомпанийн урт хугацааны үнэт зүйл ажиллагааг тогтвортой хөгжлийн болон олон улсын жишигт нийцүүлэн удирдах, байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) зарчмуудыг ТУЗ-ийн бодлого, стратеги, шийдвэр гаргалтад шингээхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэж ажиллана.

Дарга: **С. Оргодол**

Гишүүн: **А. Урангоо**

Гишүүн: **С. Жавзандулам**



“Нэткапитал финанс копораци” ББСБ ХХК нь Монгол улсад бүртгэлтэй, хязгаарлагдмал хариуцлагатай хэлбэрээр байгуулагдсан ББСБ бөгөөд Монгол улсын хууль тогтоомжоос гадна банкнаас бусад зохицуулалттай салбарын зохицуулагч Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос баталсан Компанийн засаглалын кодексийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Компанийн урт хугацааны тогтвортой хөгжилд хүрэхийн тулд бид хувь нийлүүлэгчид, харилцагчид, ажилтнууд болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалж, тэдэнтэй итгэлцэлд суурилсан хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорьдог.

СЗХ-ны 2024 оны “Компанийн засаглалын кодексийн зайны үнэлгээ”-гээр Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК нь 97.2%-ийн үнэлгээгээр 2-р байранд орсон.





NETCAPITAL 2025

ANNUAL REPORT

